

НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛИЙН БАГШ, АЖИЛЧДЫН ЁС ЗҮЙН ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг . НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү дүрэм нь Нийгэм, сэтгэл судлалын дээд сургууль /цаашид НССДС гэж товчлох/- ийн багш, ажилчдын ёс зүйн дүрмийг зөрчсөн багш, ажилчдын буруутай үйлдэл, эс үйлдэлд сахилгын зөрчил үүсгэх, сахилгын шийтгэл ноогдуулах, сахилгын шийтгэлээс чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилготой.
- 1.2 НССДС-ийн Ёс зүйн хороо нь нийт 5 хүртэлх гишүүдтэй байж болох бөгөөд дарга, гишүүд гэсэн бүрэлдэхүүнийг Захирлын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Захирлын тушаалаар батална. Хороо нь тодорхой хугацааг үл баримтлан ажиллах бөгөөд гишүүд ажлаас чөлөөлөгдөх тохиолдолд Захирлын тушаал гарган хорооны гишүүнийг нөхөн томилж ажиллуулна.
- 1.3 Ёс зүйн хороо нь үйл ажиллагаандаа Их, дээд сургууль, коллежийн багшийн мэргэжлийн ёс зүйн ерөнхий дүрэм, НССДС /Хуучнаар Энх Орчлон Дээд сургууль/- ийн Эрдмийн зөвлөлийн 2013 оны 1-р сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцэн баталсан Багш ажилчдын ёс зүйн дүрэм, Монгол Улсын Боловсролын тухай, Монгол Улын Дээд боловсролын тухай хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллана.
- 1.4 Ёс зүйн хороо нь НССДС-ийн багш ажилчдаас гаргасан ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг хүлээн авч зохицуулахдаа хууль дээдлэх, захирах, захирагдах, шударга ёсны зарчмыг мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. ХОРООНЫ ГИШҮҮДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1 НССДС-ийн Ёс зүйн хорооны гишүүд нь тус сургуульд 1-ээс доошгүй жил ажилласан, хамт олондоо нэр хүндтэй, зарчимч, шударга багш, ажилтан байна.
- 2.2 Зохих болзол шалгуурыг хангасан багш, ажилтныг Ёс зүйн хорооны гишүүнээр ажиллуулахаар холбогдох Хөтөлбөрийн хороод нэр дэвшүүлэх бөгөөд энэ асуудлыг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 2.3 Ёс зүйн хорооны гишүүнээр томилогдсон гишүүн нь өөрөө ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд Захирлын тушаал гарган Ёс зүйн хорооны гишүүнээс хасна.



НССДС-ийн Захирлын Зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцэж, Захирлын 2018 оны 2-р сарын 07-ны өдрийн 18/10 тоот тушаалаар батлав.

Гурав. ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ГОМДЛЫГ ХҮЛЭЭН АВАХ, САХИЛГЫН ЗӨРЧИЛ, МАРГААН ҮҮСГЭХ

3.1 Багш, ажилчдын ёс зүйн талаарх гомдлыг НССДС-ийн Захиргаа /Захирал/ хүлээн авна. Өргөдөл, гомдлыг албан ёсны бүртгэлд бүртгэж авсан он сар, өдөр, цагийг тэмдэглэнэ.

3.2 Өргөдөл, санал гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 2 хоногт багтаан Ёс зүйн хороонд шилжүүлэх бөгөөд Ёс зүйн хорооны дарга хорооны аль нэгэн гишүүнд цохолт хийж, урьдчилан шалгуулж, Ёс зүйн хорооны хуралдаанд бэлтгүүлнэ.

3.3 НССДС-ийн Ёс зүйн хорооны гишүүн, багшийн ёс зүйн талаар гаргасан гомдлыг хүлээн авч, дараах журмаар ажиллаж, гомдлыг барагдуулах арга хэмжээ авах үүрэгтэй. Үүнд:

3.3.1 Гомдол гаргагчтай уулзаж, гомдлын үндэслэл, нотлох баримтуудтай танилцах, гомдолд нэмэлт тайлбар бичгээр гаргуулах, гомдлоо эргүүлэн татсан бол энэ тухай баримт үйлдэх;

3.3.2 Ёс зүйн зөрчил гаргасан багш, ажилтантай уулзан, холбогдсон асуудлын талаар тодруулах, бичгээр тайлбар гаргуулах;

3.3.3 Багш, ажилтны гаргасан гэх ёс зүйн зөрчлийн талаар холбогдох хүмүүстэй уулзах, зохих баримтуудтай газар дээр нь танилцах бөгөөд энэ талаар дэлгэрэнгүй тэмдэглэл үйлдэнэ. Хууль, тогтоосон журмыг зөрчөөгүй тохиолдолд фото зураг авах, видео бичлэгийн болон бусад хэрэгслийг ашиглаж болно;

3.3.4 Гомдлыг хүлээн авч урьдчилан шалгасан Ёс зүйн хорооны гишүүн хорооны даргад танилцуулж, хорооны хуралдааны тов, хуралдааны бэлтгэлийг хангуулна.

3.4. Ёс зүйн хороонд гомдлыг албан ёсоор хүлээн авсан өдрөөс эхлэн сахилгын зөрчил үүссэнд тооцно.

3.5. Гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногт багтаан урьдчилан шалгалт хийж, ёс зүйн хуралдаанд шилжүүлнэ.

Дөрөв. БАГШИЙН ЁС ЗҮЙН ХУРАЛДААНЫ ДЭГ

4.1. Багш, ажилтны ёс зүйн зөрчилтэй асуудлыг урьдчилан шалгасны эцэст уг зөрчилд тухайн багш, ажилтан ямар буруутай болох, багш, ажилтанд сахилгын шийтгэл оногдуулах эсэх асуудлуудыг Ёс зүйн хорооны хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

- 4.2. Ёс зүйн хорооны гишүүдийн ирц 75 хувиас доошгүй байж хурал хүчинтэйд тооцогдоно.
- 4.3. Хорооны гишүүдэд хэлэлцэх асуудал урьдчилан шалгасан нотлох баримтуудын талаар, бичгээр танилцуулга хүргүүлэхийн сацуу асуудлыг урьдчилан шалгасан хорооны гишүүн хуралдааны үед танилцуулга үйлдэнэ.
- 4.4. Хорооны хуралдааны дэгийг хуралдаанд оролцогчид олонхийн саналаар тогтооно. Хорооны хуралдаанд ёс зүйн зөрчил гаргасан буюу холбогдсон багш, ажилтан, гомдол гаргагч нар өөрийн тайлбарыг гаргах эрхтэйгээр оролцож болно.
- 4.5. Хорооны гишүүд хуралдаанд оролцогчдод асуулт тавьж, тайлбар авч болно.
- 4.6. Ёс зүйн хорооны хуралдааныг Ёс зүйн хорооны дарга удирдана.
- 4.7. Ёс зүйн хорооны нарийн бичиг хуралдааны явцын тэмдэглэлийг хөтлөнө. Тэмдэглэлд хуралдаан даргалагч, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурж баталгаажуулна.
- 4.8. Хорооны хуралдаанаар ёс зүйн зөрчил гаргасан багш, ажилтанд сахилгын ямар шийтгэл ноогдуулах эсвэл гэм буруугүй гэдгийг эцэслэн шийдвэрлэсэн тогтоолыг олонхийн саналаар гаргана. Тогтоолд хуралдаанд оролцогсод гарын үсэг зурж, албан ёсны болгоно. Тогтоолын нэг хувийг гомдол гаргагчид хүргүүлнэ.
- 4.9. НССДС-ийн энэхүү тогтоолыг үндэслэн зөрчил гаргасан багш, ажилтанд сахилгын шийтгэл ноогдуулах асуудлыг шийдвэрлэнэ. Ингэхдээ “Монгол Улсын Хөдөлмөрийн хууль”, НССДС-ийн Хөдөлмөрийн дотоод журам, “Их, дээд сургууль, коллежийн багш, ажилчдын ёс зүйн” дүрмийг удирдлага болгоно.
- 4.10. Ёс зүйн зөрчил гаргаж, сахилгын шийтгэл хүлээсэн багш нэг жилийн дотор ёс зүйн ямар нэг зөрчил давтан гаргаагүй ажилласан бол түүний хүсэлтийг үндэслэн Ёс зүйн хорооны сахилгын шийтгэлийг хугацаанаас өмнө арилгах саналыг НССДС-ийн Захиралд гаргаж болно.